

**Нутаг дэвсгэрийн маргаан, түүнийг олон улсын  
эрх зүйн дагуу шийдвэрлэх нь**

**Territorial Disputes and Their Settlement Under  
International Law**

Энхээгийн Туулайхүү

*Хууль зүйн ухааны магистр (LL.M.).*

*Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн  
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш*

*Улаанбаатар хот, Монгол Улс*

*e.tuulaikhuu@num.edu.mn*



### [Товч утга]

Нутаг дэвсгэрийн маргаан нь олон улсын эрх зүй, түүхэн өв, хүчний харьцаа, дотоод улс төрийн хүчин зүйлсийн уулзварт оршдог нарийн төвөгтэй үзэгдэл бөгөөд түүнийг энхийн аргаар шийдвэрлэх үйл явц нь эрх зүйн зохицуулалтаас давсан олон янзын нөхцөл байдлаас хамаардаг. Энэ өгүүлэлд эхлээд нутаг дэвсгэрийн маргааныг эрх зүйн болон улс төрийн практикийн огтлолцолд шинжилж, маргаан оршин буй эсэхийг тогтоох Олон улсын шүүхийн шалгуур болон “позитив эсэргүүцэл” гэх ойлголтын ач холбогдлыг тайлбарласан. Цаашлаад НҮБ-ын Дүрмийн дагуу энхийн аргаар шийдвэрлэх механизмын эрх зүйн үндэс, энхийн аргуудын хэрэглээ нь улсуудын стратегийн сонирхол, институтийн орчинтой хэрхэн уялддагийг тодорхойлохыг эрмэлзэв. 1945–2015 оны практикийг шинжлэхэд хэлэлцээ давамгайлж, маргаан удаан үргэлжлэх тусам заавал биелэгдэх механизмыг сонгох магадлал буурч буй хандлага ажиглагдсан. Харин 2015 оноос хойших үйл явцад бүс нутгийн зуучлалын ач холбогдол нэмэгдэж, олон улсын шүүх, арбитрын шийдвэр маргааны динамикт бодит нөлөө үзүүлж буй ч олон маргаан улс төрийн статусквотоо хадгалсан хэвээр байна. Судалгааны үр дүн нь нутаг дэвсгэрийн маргааныг энхийн аргаар шийдвэрлэх нь олон улсын эрх зүйн зайлшгүй шаардлага боловч түүний үр нөлөө стратегийн тооцоолол, институтийн нөлөө, бүс нутгийн динамиктай салшгүй уялдаатай хэвээр байгааг харуулна.

### [Түлхүүр үг]

Нутаг дэвсгэрийн маргаан, позитив эсэргүүцэл, НҮБ-ын дүрэм, маргааныг энхийн аргаар шийдвэрлэх, олон улсын шүүх ба арбитр.

## I. Удиртгал

Нутаг дэвсгэрийн маргаан нь олон улсын харилцааны хамгийн төвөгтэй, хамгийн удаан үргэлжилдэг, хамгийн өндөр өртөгтэй асуудлуудын нэг бөгөөд түүхэн өв, колоницлолын үлдэц, стратегийн байрлал, байгалийн баялаг, үндэсний аюулгүй байдал, улс төрийн нөхцөл зэрэг олон хүчин зүйлтэй холбогдон үүсдэг. XX зуунд ч, XXI зуунд ч нутаг дэвсгэрийн маргаан нь зөрчилдөөн, хүч хэрэглэх, бүс нутгийн тогтворгүй байдлын нэг гол эх үүсвэр хэвээр байна.

НҮБ-ын Дүрмийн 2(3) болон 33 дугаар зүйлд зааснаар гишүүн улсууд маргаанаа энхийн аргаар шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд энэ нь олон улсын эрх зүйн тогтолцооны суурь зарчим юм. Ингэхдээ энхийн аргаар шийдвэрлэх механизмын хэрэглээ нь дан ганц эрх зүйн асуудал биш. Улсуудын стратегийн тооцоолол, хүчний харьцаа, дотоод улс төрийн байдал, бүс нутгийн орчин, олон улсын институтийн нөлөө зэрэг цөөнгүй хүчин зүйл маргаан шийдвэрлэх үйл явцад нөлөөлдөг. Энэ хүрээнд өгүүлэл нь нутаг дэвсгэрийн маргааныг дараах дөрвөн түвшинд авч үзнэ.

*Нэгдүгээрт*, нутаг дэвсгэрийн маргаан оршин буй эсэхийг тогтоох талаарх Олон улсын байнгын шүүх (PCIJ) болон Олон улсын шүүх (ICJ)-ийн практик, “позитив эсэргүүцэл (positive opposition)” -ын тухай ойлголт, эрх зүйн болон улс төрийн маргааны зааг, нутаг дэвсгэрийн маргааны хамрах хүрээг тайлбарлана. *Хоёрдугаарт*, НҮБ-ын Дүрмийн дагуу маргааныг энхийн аргаар шийдвэрлэх механизмын эрх зүйн үндэс, маргаан шийдвэрлэх аргуудын онцлог, тэдгээрийн хэрэглээг жишээлэн авч үзнэ. *Гуравдугаарт*, 1945–2015 онд нутаг дэвсгэрийн маргааныг энхийн аргаар шийдвэрлэсэн байдлын талаарх судалгаанд ажиглалт хийж, маргаан шийдвэрлэхэд заавал биелэгдэх, заавал эс биелэгдэх аргууд хэрхэн хэрэглэгдэж ирсэн хандлагыг тодорхойлно. *Дөрөвдүгээрт*, 2015 оноос хойших практикт өмнөхтэй харьцуулахад ямар нийтлэг болон ялгаатай байдал буйг шинжилж, хэтийн төлөвийн талаар эргэцүүлнэ.

Ийм маягаар өгүүлэл нь нутаг дэвсгэрийн маргааныг эрх зүйн болон бодит практикийн огтлолцолд шинжилж, энхийн аргаар шийдвэрлэх механизмын өнөөгийн төлөв, сорилт, боломжийг нийтлэг байдлаар тодорхойлоход хувь нэмэр оруулах зорилготой.

## II. Нутаг дэвсгэрийн маргааны тухай ойлголт, түүний оршин буй эсэхийг тодорхойлох нь

Марсело Г.Кохэн (Marcelo G. Kohen), Мамаду Эбье (Mamadou Hébié) нарын тайлбарласнаар олон улсын эрх зүйд

“зөрчилдөөн”(conflict), “маргаан”(dispute) гэх нэр томъёонуудын хэрэглээ нь шууд утгаараа ижил утгатай биш аж.<sup>1</sup> Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бутрос БутросГали (Boutros Boutros-Ghali) 1992 онд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хуралдаан дээр хэлсэн үгэндээ “оршин буй маргааныг зөрчилдөөн болон даамжрахаас сэргийлэх” тухай дурдаж байжээ.<sup>2</sup> Маргаан гэдэг нь үндсэндээ хоёр буюу түүнээс дээш этгээдийн зүгээс эсэргүүцэж буй асуудлын агуулгад хамаарах бол зөрчилдөөн нь хурцадмал байдал болон хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх зэрэг өөр өөр төрлийн албадлагын арга хэмжээ авахтай холбоотой онцгой нөхцөл байдалтай холбогдоно.<sup>3</sup>

Нутаг дэвсгэрийн маргаан оршин буй нь харилцан адилгүй шалтгаантай байж болно. Маргаан бодитоор оршин байж гэмээнэ олон улсын шүүх, арбитр шийдвэрлэх боломжтой. Практикт маргааны нэг тал нь маргаан оршин байгаа эсэхийг үгүйсгэх тохиолдол гардаг. Ийм учраас Олон улсын байнгын шүүх (Permanent Court of International Justice)<sup>4</sup> болон Олон улсын шүүх (International Court of Justice)<sup>5</sup>-ийн аль аль нь “маргаан” гэх ойлголтын агуулгыг нарийвчлан, хүрээг тодорхойлсон байдаг.

Олон улсын байнгын шүүх *Мавромматисийн хэрэг* (Mavrommatis case)-т маргааныг “Эрх зүйн тодорхой асуудал болон үйл баримт (факт)-ын талаарх зөрөлдөөн, эсвэл хоёр этгээдийн эрх зүйн байр суурь, эрх ашгийн зөрчилдөөн”<sup>6</sup> гэж үзсэн бөгөөд энэ нь ихээхэн эш татагддаг.

Олон улсын шүүх энэ ойлголтыг *Баруун Өмнөд Африктай холбоотой хэргүүдэд*<sup>7</sup> илүү тодорхой тайлбарласан. Үүнд “Зөвхөн ашиг сонирхлын зөрчил байгаагаар маргаан оршин байна гэж үзэх боломжгүй бөгөөд маргаан байгаа эсэхийг тогтоохын тулд нэг тал

<sup>1</sup> Marcelo G. Kohen and Mamadou Hébié, “Territorial Conflicts and Their International Legal Framework,” in *Research Handbook on Territorial Disputes in International Law*, ed. Marcelo G. Kohen and Mamadou Hébié (Cheltenham: Edward Elgar, 2018), 5

<sup>2</sup> Boutros Boutros-Ghali, *Statement to the UN Security Council*, U.N. Doc A/47/277 (June 17, 1992).

<sup>3</sup> Marcelo G. Kohen and Mamadou Hébié, *supra* note 1.6.

<sup>4</sup> Олон улсын байнгын шүүх (Permanent Court of International Justice) нь Үндэстнүүдийн Лигийн шүүх байсан бөгөөд 1922-1946 оны хооронд улс хоорондын 29 маргааныг шийдэж, 27 зөвлөх дүгнэлт (advisory opinion) гаргасан.

<sup>5</sup> Олон улсын шүүх (International Court of Justice) нь НҮБ-ын шүүх. 1945 онд байгуулагдсан. Улс хоорондын маргааныг шийдвэрлэж, заавал биелэгдэх, эцсийн шийдвэр гаргахаас гадна эрх зүйн асуудлаар зөвлөх дүгнэлт гаргана.

<sup>6</sup> *Mavrommatis Palestine Concessions* (Greece v. United Kingdom), PCIJ Series A, No. 2 (1924), 11

<sup>7</sup> Энд *Баруун Өмнөд Африктай холбоотой хэргүүд* гэдэгт Этиоп ба Өмнөд Африк (Ethiopia v. South Africa); Либери ба Өмнөд Африк (Liberia v. South Africa) маргаан тус тус хамаарна.

маргаан байгаа гэж мэдэгдэх хангалттай биш. Энэ нь маргаан байгааг нотлох үндэслэл дангаар болохгүй бөгөөд маргаан байхгүй гэж үгүйсгэх нь маргаан байхгүйг дангаар нотлохгүйтэй адил. Хоёр талын ашиг сонирхол зөрчилдөж байгааг харуулах нь ч бас хангалтгүй. Гол нь нэг талын нэхэмжлэлийг нөгөө тал нь позитив байдлаар эсэргүүцэж буйг харуулах шаардлагатай<sup>8</sup> гэдгийг онцолсон.

“Позитив эсэргүүцэл” (positive opposition) хэрхэн илэрдэг нь тохиолдол бүрд харилцан адилгүй байна. Үндсэндээ нэг тал нөгөө талын үйлдэл эсвэл нэхэмжлэлийн эсрэг эсэргүүцэл гаргасан үед илэрдэг. Нутаг дэвсгэрийн маргаанд нэг тал тухайн нутаг дэвсгэрт бүрэн эрхтэй гэж мэдэгдэхэд нөгөө тал анх удаа эсэргүүцэх, эсхүл нэг тал анх эсэргүүцээнийг нөгөө тал буруушаах үед байна гэж үздэг. Гэхдээ шүүх “Нэг талын нэхэмжлэлийг нөгөө тал позитив байдлаар эсэргүүцэж байгааг заавал ил тод, үгээр илэрхийлэх (expressis verbis) шаардлагагүй. Маргаан байгаа эсэхийг тогтоохдоо, бусад асуудлын адил, тухайн талын байр суурь, хандлагыг тухайн талын албан ёсны үзэл бодол ямар ч байсан, оюун дүгнэлтийн үндсэн дээр тогтоож болно<sup>9</sup>” гэжээ.

*Цөмийн зэвсгийн өрсөлдөөнийг зогсоох болон цөмийн зэвсгийг устгахтай холбоотой хэлэлцээний үүргийн талаарх Маршаллын арлууд ба Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант улсын хэрэг*<sup>10</sup>-т Олон улсын шүүх маргаан байгаа гэж үзэх босгыг өндөрсгөсөн. Тодруулбал, шүүх нэхэмжлэгч позитив байдлаар эсэргүүцэж байгааг хариуцагч тал мэдэж байсан, эсвэл мэдэхгүй байх боломжгүй байсан эсэхийг нотлох баримтын үндсэн дээр тогтоох<sup>11</sup> шаардлагатай.

Нутаг дэвсгэрийн тодорхой маргаанд нэг тал маргаан байгааг үгүйсгэх эсхүл байсан маргааныг хэдийн шийдвэрлэсэн гэж үзэж байж бас болно. Энэ тохиолдолд «маргаан байгаа эсэх талаарх маргаан»-ыг хэрхэх вэ гэдэг асуулт гарна. Энэ асуудлыг *Нутаг дэвсгэрийн болон далайн маргааны талаарх Никарагуа ба Колумбийн хэрэг* (Territorial and Maritime Dispute (Nicaragua v. Colombia) болон *Эль Сальвадор/Хондурасын хэрэг* (El Salvador/Honduras)-т шүүх тус тус авч үзсэн. Эль Сальвадор/Хондурасын хэрэгт Эль Сальвадор улс Эль Тигр гэх

<sup>8</sup> *South West Africa* (Ethiopia v. South Africa; Liberia v. South Africa), Preliminary Objections, 1962 I.C.J. 319, 328.

<sup>9</sup> *Land and Maritime Boundary between Cameroon and Nigeria* (Cameroon v. Nigeria; Eq. Guinea intervening), Preliminary Objections, 1998 I.C.J. 275, 315, para. 89.

<sup>10</sup> Англиар хэргийн нэр нь *Obligations concerning Negotiations relating to Cessation of the Nuclear Arms Race and to Nuclear Disarmament* (Marshall Islands v. United Kingdom).

<sup>11</sup> *Obligations concerning Negotiations relating to Cessation of the Nuclear Arms Race and to Nuclear Disarmament* (Marshall Islands v. United Kingdom), Preliminary Objections, 2016 I.C.J. 1, 18, para. 41

арлын талаар маргасан бол Хондурас үүнд маргаан байхгүй хэмээж байв. Олон улсын шүүх энэ хэрэгт “тухайн арлын талаар маргаан оршин буйг тухайлсан хийгээд маргасан нэхэмжлэлийн нэг сэдэв болж буй фактаас тодорхойлж болно” гэж дүгнэсэн. Ингэх замаар шүүх “маргаан байгаа эсэх нь талуудын нэхэмжлэлийн объектив хүчин төгөлдөр байдлаас хамаарахгүй” болохыг тогтоосон бөгөөд Эль Тигрийн бүрэн эрхийн талаар маргаан оршин буй ба тус нутаг дэвсгэр Хондурас улсад хамаарна<sup>12</sup> гэж шийдвэрлэжээ.

*Никарагуа ба Коломбийн хэрэгт* гол асуудал нь Карибийн тэнгис дэх Сан Андрес олтриг (бүлэг арал) дахь of Сан Андрес (San Andrés), Провиденсия (Providencia), Санта Каталина (Santa Catalina) гэх гурван арлын тухайд хоёр улсын хооронд маргаан байгаа эсэхийг тогтоох явдал байсан. 1928 оны гэрээгээр Никарагуа улс эдгээр арал дахь Колумбын бүрэн эрхийг зөвшөөрсөн ч уг гэрээ 1980 онд хүчингүй болжээ. Гэхдээ шүүх “тус гэрээгээр тогтоосон хил нь гэрээнээс эрх зүйн хувьд бие даасан учраас хүчин төгөлдөр” гэж үзэн талуудын хооронд эдгээр гурван арлын тухайд одоо маргаан байхгүй гэж үзсэн байна.<sup>13</sup>

### **III. Эрх зүйн болон улс төрийн маргааныг зааглах нь**

Олон улсын шүүх “бүрэн эрхт улсуудын хоорондын маргаан нь уг мөн чанараараа улс төрийн хүрээнд үүсэх талтай бөгөөд ихэвчлэн илүү өргөн хүрээтэй, удаан үргэлжилсэн улс төрийн маргааны нэг хэсэг болдог”<sup>14</sup> гэж дүгнэсэн байдаг. Энэ үүднээс эрх зүйн болон улс төрийн маргааныг хооронд нь зааглаж болох ч энэ нь нэг маргаанд эрх зүйн болон улс төрийн элементүүд нэгэн зэрэг агуулагдаж болохгүй гэсэн үг биш юм. Нутаг дэвсгэрийн маргааны хувьд улс төрийн шинж нь нэхэмжлэл гаргах уг шалтгаантай холбогдох бөгөөд талуудын зүгээс маргааныг зохицуулах явцад ч үргэлжилж болно. Ялгаа заагийг тухайн шаардлагын шинж чанараар тодорхойлж болно. Хэрэв нэг улс эрх зүйн үндэслэлээр тухайн нутаг дэвсгэр өөрт нь харьяалагдана гэж үзэж, нөгөө тал ч мөн адил өөрийн бүрэн эрхийг нотлохдоо эрх зүйн үндэслэл гарган тавьж буй бол энэ нь эрх зүйн маргаан юм. Харин нэг улс тухайн нутаг дэвсгэр нь одоогоор өөр улсын бүрэн эрхийн дор байгааг хүлээн зөвшөөрч байгаа ч эдийн засаг, газарзүй, угсаа гарвал, эсвэл өөрт таатай бусад шалтгаанаар өөрт нь шилжих ёстой гэж үзэж буй бол энэ нь улс төрийн маргаан бөгөөд олон улсын эрх

<sup>12</sup> *Land, Island and Maritime Frontier Dispute* (El Salvador/Honduras; Nicaragua intervening), Judgment, 1992 I.C.J. 351, 555, 556.

<sup>13</sup> *Territorial and Maritime Dispute* (Nicaragua v. Colombia), Preliminary Objections, 2007 I.C.J. 832, 861, 873–74, paras. 88–90, 138

<sup>14</sup> *Aegean Sea Continental Shelf* (Greece v. Turkey), Judgment, 1978 I.C.J. 3, para. 29.

зүйн хэм хэмжээнд үндэслээгүй байна гэж үзэж болно. Чехословак улсын нутаг дэвсгэр Судетийн тухайд Нацист Германы тавьж байсан шаардлага нь ийм төрлийн маргааны сонгодог жишээ байсан гэдэг.<sup>15</sup>

Сэр Роберт Женнингс (Sir Robert Jennings) “Техникийн болон бодит утгаараа “эрх зүйн маргаан” гэдэг нь шүүхээр шийдвэрлэхэд тохиромжтой хэлбэрт боловсруулсан, тодорхой асуудлуудыг цогц хэлбэрт буулгасан маргааныг хэлнэ”<sup>16</sup> гэж тайлбарлажээ. Ийм нөхцөлд, эрх зүйн бус шаардлага нь нутаг дэвсгэрийн маргааныг олон улсын эрх зүйн дагуу шийдвэрлэх үүрэгтэй олон улсын шүүх, арбитрын байгууллагад амжилт олохгүй. Тухайлбал, Хорват/Словенийн арбитрын хэрэг нь арбитрын хэлэлцээрээр тогтоосон эрх хэмжээний хүрээнд арбитр хэрхэн ажилладгийн нэг тодорхой жишээ болсон. Үүнд арбитрын бүрэлдэхүүн нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг хэрэглэхээс бусдаар эрх зүйн хувьд хил тогтоох эрх мэдэлгүй; эрх зүйн хувьд ач холбогдолгүй хүчин зүйлс, эсвэл талууд илэрхий тохиролцоо замаар авч үзэхгүй байхаар шийдсэн асуудлуудыг шийдвэр гаргахдаа харгалзан үзэж болохгүй; арбитрын бүрэлдэхүүн тухайн асуудлыг эрх зүйн үүднээс шийдвэрлэх үүрэгтэй болохоос түүхэн, улс төрийн, социологийн үүднээс шийдвэрлэх үүрэггүй болохыг онцолсон байдаг.<sup>17</sup>

#### IV. Нутаг дэвсгэрийн маргааны хамрах хүрээ

Нутаг дэвсгэр нь үндсэндээ хуурай газарт суурилдаг боловч зөвхөн түүгээр үл хязгаарлагдана. Нутаг дэвсгэрийн хүрээнд арал шинээр үүссэн тохиолдолд улсын бүрэн эрхэд хамаарах нутаг дэвсгэрийн нэг хэсэг болох боломжтой. Хуурай газраас бусад гол мөрөн, нуур, газрын доорх ус зэрэг усан тогтоц, дотоод ус, түүхэн ус, нутаг дэвсгэрийн далай (territorial sea), олтригийн ус гэх мэт далайн бүс нь нутаг дэвсгэрийн эрх зүйн дэглэмд хамаарна. Мөн хуурай газрын болон далайн бүсийн хэвлий нь үүнд багтана. Хуурай газар болон далайн бүсийн дээр орших агаарын орон зай нь нутаг дэвсгэрийн нэг хэсэг болох тул энд улс бүрэн эрхээ мөн хэрэгжүүлнэ.<sup>18</sup>

Харин эх газрын хормой (continental shelf), эдийн засгийн онцгой бүс (exclusive economic zone)-д эргийн улс нь “бүрэн эрх” хэрэгжүүлнэ. Далайн эрх зүйн тухай НҮБ-ын конвенц (UNCLOS)-ийн 11 дүгээр

<sup>15</sup> Нутаг дэвсгэрийн маргааны эрх зүйн үндэслэлийн талаар Kohen ба Hébié нарын өгүүллийг үз. Мөн Судетийн жишээг Dieter Blumenwitz-ийн ‘The Sudeten German Question’ (1994) бүтээлээс лавлаж болно.

<sup>16</sup> Robert Jennings, “Reflections on the Term ‘Dispute,’” in *Essays in Honour of Wang Tieya*, ed. Ronald MacDonald (Dordrecht: Martinus Nijhoff, 1993), 403

<sup>17</sup> Croatia/Slovenia Arbitration, Award, (PCA, 2017), 1, at 108, para. 335.

<sup>18</sup> Malcolm N. Shaw, *International Law*, 9th ed. (Cambridge: Cambridge University Press, 2021), pp.488–495.

зүйлд зааснаар нутаг дэвсгэрийн далай дахь улсын эрх нь далайн эргийн эзэмшлийг илтгэнэ. Энэ зарчим нь тухайн улсын харьяанд байгаа бусад далайн бүсэд ч адилхан үйлчилнэ. Далайн эрх зүйн тухай конвенцын 3 дугаар зүйлийн дагуу нутаг дэвсгэрийн далайн өргөн нь суурь шугам (baseline)-аас 12 милл хүртэл үргэлжилнэ. Харин эсрэг болон зэргэлдээх улсуудын хооронд хил тогтооход тус конвенцын 15 дугаар зүйлд зааснаар онцгой тохиолдлоос бусад үед дундаж шугамыг баримтална.<sup>19</sup> Эдгээр нь олон улсын эрх зүйн заншлын шинжтэй бөгөөд нутаг дэвсгэрийн бүрэн эрхт байдал олж авахад гэхээсээ далайн эрх зүйд холбогдох тул энд дэлгэрүүлэн авч үзэхгүй.

Нутаг дэвсгэрийн маргааныг онолын үүднээс нутаг дэвсгэрт хамаарах маргаан, хил хязгаарыг тогтоохтой холбоотой маргаан гэж хувааж ирсэн туршлага байдаг.<sup>20</sup> Эдгээрт ялгаатайгаар хандах, өөр өөр хэм хэмжээ хэрэглэх эсэх талаар Олон улсын шүүхийн практикт мөн яригдаж байсан тохиолдол бий. Гэхдээ эдүгээ аль аль төрлийн маргаанд ижил дүрэм хэрэглэх талаар нийтлэг ойлголттой болсон гэж үзэж байна.<sup>21</sup>

Хилийн маргаан нь хилийг тодорхойлох үйл явц (процесс)-ын аль ч үе шатанд үүсэж болно. Үйл явц нь делимитаци (delimitation), демаркаци (demarcation) гэсэн хоёр үндсэн үе шатыг өөртөө багтаана. Олон улсын шүүх нь *Хуурай газрын болон далайн хилийн маргааны талаарх Камерун ба Нигерийн хэрэг* (the Land and Maritime Dispute (Cameroon v. Nigeria))-т “хилийн делимитаци нь хилийг “тодорхойлох”-оос бүрдэх бол хилийн демаркаци нь урьдаар делимитаци хийснийг газар дээр нь тэмдэглэх ажиллагаанаас бүрддэг. Энэ хэрэгт талууд тус тусын нутаг дэвсгэрийн хооронд делимитаци хийх зорилготой баримт бичгүүд оршин байгааг, тэдгээрийн хүчин төгөлдөр байдлыг хүлээн зөвшөөрсөн. Түүнчлэн, аль аль тал нь шүүхээс демаркаци хийхийг хүсэхгүй байгаагаа удаа дараа илэрхийлсэн бөгөөд энэ ажлыг дараагийн шатанд өөрсдөө хариуцахаар төлөвлөсөн” гэжээ.<sup>22</sup>

Нутаг дэвсгэрийн зарим маргаан нь хоёр улсын бүрэн эрхийн хязгаарыг зааглах хилийн шугамтай холбоотой байдаг бол зарим нь тусгаарлагдсан газар нутгийн хэсэгтэй, жишээлбэл, арал эсвэл

<sup>19</sup> Далайн эрх зүйн НҮБ-ын конвенцыг [https://www.un.org/depts/los/convention\\_agreements/texts/unclos/unclos\\_e.pdf](https://www.un.org/depts/los/convention_agreements/texts/unclos/unclos_e.pdf)-аас үз.

<sup>20</sup> Paul De La Pradelle, *La Frontière: Étude de droit international* (Paris: Les Éditions Internationales, 1928), 140–143.

<sup>21</sup> Marcelo G. Kohen, Mamadou Hébi, “Territorial conflicts and their international legal framework”, in *Research Handbook on Territorial Disputes in International Law*, ed. Marcelo G. Kohen and Mamadou Hébié (Cheltenham: Edward Elgar, 2018), p.10

<sup>22</sup> *Land and Maritime Boundary between Cameroon and Nigeria* (Cameroon v. Nigeria; Equatorial Guinea intervening), Merits, 2002 I.C.J. 303, 359, para. 84.

тодорхой зааглагдсан газар нутагтай холбоотой байдаг. Олон улсын шүүх *Буркина Фасо ба Нигерийн хилийн маргааны хэргийг* хэлэлцэхдээ “Хилийн шугам” гэдэг нь улсын бүрэн эрхийн бүсүүдийн хоорондох зааг шугамыг илэрхийлдэг бөгөөд энэ нь газрын гадаргуу дээр төдийгүй газрын хэвлий болон дээгүүр орших агаарын орон зайд ч хамаарна”<sup>23</sup> хэмээн тайлбарласан.

Нутаг дэвсгэрт хамаарах маргаан, хилийн маргаан гэж тус тусдаа ярих нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхэд эрх зүйн ач холбогдолгүй. Энэ талаар, тухайлбал, *Буркина Фасо ба Малигийн хилийн маргааны хэргийг* шийдвэрлэхдээ шүүхийн өгсөн тайлбараас харж болно. Үүнд “талууд энэ маргааныг хэрхэн ангилах талаар - зарим хуульчийн гаргасан “хилийн маргаан” буюу “делимитацийн (зааг тогтоох) маргаан” болон “нутаг дэвсгэрт хамаарах маргаан” гэх ялгааны үүднээс - удаан хугацаанд маргасан. Энэ ялгааны дагуу эхнийх нь газарзүйн хувьд бие даасан шинжгүй газар нутгийн хэсэгт хамаарах зааг тогтоох ажиллагааг илэрхийлдэг бол хоёр дахь нь бүтэн газарзүйн нэгжийг хамарсан байна. Гэвч бодит байдал дээр, энэ хэргийг оролцуулаад ихэнх тохиолдолд дээрх нь төрөл зөрүүтэй гэхээсээ илүү тухайн ажиллагаа хэрхэн явагдаж байгаагийн л ялгаа юм. Ямар ч делимитацийн ажиллагаа нь - маргаантай бүс хэр жижиг байхаас үл хамааран - тухайн шугамын хоёр талд орших газар нутгийг хуваарилах үр дагавартай байдаг”<sup>24</sup> гэж дүгнэсэн.

Аралтай холбоотой маргаан нь тодорхойлолтын хувьд “нутаг дэвсгэрт хамаарах” маргааны хамгийн тод жишээ бөгөөд зарим тохиолдолд гэрээ болон эрхийн тайлбарт тулгуурлан шийдвэрлэгддэг бол зарим тохиолдолд *effectivités* (бодитоор эрх мэдэл хэрэгжүүлэх)-д үндэслэдэг. Арал нь улсын нутаг дэвсгэрийн нэг хэсэг бөгөөд иймээс хууль ёсоор эзэмшиж болох объект юм.

Усаар хүрээлэгдсэн газрын хэсгийг “жинхэнэ утгаараа арал” (*islands stricto sensu*) эсвэл “хад” (*rocks*) гэж үзэх асуудалд маргаан гарах нь олонтаа. Далайн эрх зүйн тухай НҮБ-ын конвенцын 121 (3)-р зүйлд<sup>25</sup> зааснаар хад нь эрх зүйн хувьд эдийн засгийн онцгой бүс эсвэл эх газрын хормой үүсгэж чадахгүй. Гэхдээ ингэж үзэх нь өргөн утгаараа хад нь арал (*islands lato sensu*) мөн эсэхийг үгүйсгэхгүй. Өмнөд Хятадын тэнгисийн маргаанд Олон улсын байнгын арбитрын шүүх (Permanent Court of Arbitration) нь “121 дүгээр зүйлийн хүрээнд

<sup>23</sup> *Frontier Dispute* (Burkina Faso/Niger), Judgment, 2013 I.C.J. 44, para. 63

<sup>24</sup> *Frontier Dispute* (Burkina Faso/Mali), Merits, 1986 I.C.J. 554, 563, para. 17

<sup>25</sup> Далайн эрх зүйн тухай НҮБ-ын конвенцын 121 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хүн амьдрах, аж ахуйн бие даасан аливаа үйл ажиллагаа явуулах боломжгүй хаданд эдийн засгийн онцгой бүс, залгаа бүс гэж байхгүй гэж заасан.

хад нь арлын нэг төрөл юм. Арал нь геологийн эсвэл геоморфологийн<sup>26</sup> тодорхойлолт шаардахгүйгээр “байгалийн гаралтай газрын хэсэг” гэж тодорхойлогдоно<sup>27</sup> гэж үзсэн. Иймээс хад нь нутаг дэвсгэрт тооцогдох учраас эзэмшиж болох объект юм.

Харин нам усны үед ил гардаг өндөрлөг (low-tide elevations)-ийн хувьд асуудал илүү төвөгтэй. *Катар ба Бахрейний* хэрэгт Олон улсын шүүх энэ асуудлыг шинжилсэн. Шүүхээс “Олон улсын гэрээний эрх зүй нь нам усны үед ил гардаг өндөрлөгийг “нутаг дэвсгэр” гэж үзэх эсэх талаар тун чимээгүй. Шүүхийн зүгээс нам усны үед ил гардаг өндөрлөгийг хууль ёсоор эзэмшихийг зөвшөөрсөн эсвэл үгүйсгэсэн заншлын эрх зүйн хэм хэмжээг үүсгэхүйц нэгдмэл, өргөн тархсан улс хоорондын практик байгааг мэдэхгүй байна (...) Оршин буй цөөн хэм хэмжээ нь нам усны өндөрлөгийг аралтай адилаар нутаг дэвсгэр гэж дүгнэх үндэслэл болохгүй. Арлууд нь *terra firma* буюу хуурай газар гэдэг нь хэзээ ч маргаан дагуулж байгаагүй бөгөөд энд нутаг дэвсгэр олж авахтай холбоотой эрх зүйн дүрэм, зарчим үйлчилдэг. Харин далайн эрх зүйн хүрээнд арал болон нам усны өндөрлөгт хамаарах үр дагавар нь ихээхэн ялгаатай. Иймээс бусад эрх зүйн дүрэм, зарчим байхгүй нөхцөлд нам усны өндөрлөгийг бүрэн эрх олж авах үүднээс арал эсвэл бусад газар нутагтай адилтган үзэх боломжтойн тогтоогдохгүй байна”<sup>28</sup> гэж үзсэн.

2012 онд *Нутаг дэвсгэрийн ба далайн маргааны талаарх Нигарагуа ба Колумбын хэрэгт* шүүх нь нам усны үеийн өндөрлөгийг нутаг дэвсгэр байдлаар эзэмших боломжтой гэх үндэслэлийг илүү тодорхой няцаасан. Шүүх энэ маргаанд дээр дурдсан Катар ба Бахрейний хэргийн шийдвэрийг эш татаж, арал хэр жижиг эсэхээс үл хамааран эзэмших боломжтой гэдэг нь олон улсын эрх зүйн дагуу сайтар тогтоогдсон бол нам усны үеийн өндөрлөгийн тухайд эсрэгээрээ, харин “далайн эргийн улс нь нутаг дэвсгэртээ орших нам усны үеийн өндөрлөгт өөрийн нутаг дэвсгэрийн усанд бүрэн эрхтэйн хувьд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ”<sup>29</sup> гэж дүгнэсэн. Цаашлаад шүүх Малайз, Сингапур улсуудын маргаанд Өмнөд Лэдж (South Ledge)-ийг нам усны өндөрлөг гэж үзсэн тул дээрх дүгнэлтийг үндэслэн тус өндөрлөгт Малайз эсвэл Сингапурын аль нь бүрэн эрхтэйг

<sup>26</sup> Геоморфологи нь газар дэлхийн гадаргуугийн дүрс хэлбэр, гарал үүсэл, хөгжил газар зүйн тархалтын онцлог шинжийг судалдаг геогийн салбар шинжлэх ухаан (<https://www.mongoltoli.mn/dictionary/detail/23799>).

<sup>27</sup> *South China Sea Arbitration* (The Phillipines v. China), Final Award, Annex VII Tribunal, (2016), para. 481

<sup>28</sup> *Maritime Delimitation and Territorial Questions between Qatar and Bahrain* (Qatar v. Bahrain), Merits, 2001 I.C.J. 40, 102, paras. 205–6.

<sup>29</sup> *Territorial and Maritime Dispute* (Nicaragua v. Colombia), Judgment, 2012 I.C.J. 624, 641, para. 26.

тодорхойлохоос татгалзсан бөгөөд энэ үүднээс Өмнөд Лэдж нь аль улсын нутаг дэвсгэрийн далайд оршиж байна, тус улсад хамаарна гэж шийдвэрлэсэн.

## **V. Нутаг дэвсгэрийн маргааныг олон улсын эрх зүйн дагуу шийдвэрлэх явдал ба бодит байдал**

### **1. Олон улсын эрх зүйн үндэс**

НҮБ-ын Дүрэмд гишүүн улсуудыг маргаанаа энхийн замаар шийдвэрлэхийг үүрэг болгосон. Дүрмийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “бүх гишүүн нь улс хоорондын маргаанаа олон улсын энх тайван, аюулгүй байдал, шударга ёсонд хор хүргэхгүйгээр эв зүйгээр шийдвэрлэнэ” гэж заасан. Мөн зүйлийн дараагийн хэсэгт дурдсанаар “бүх гишүүн нь олон улсын харилцаандаа аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал буюу улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр сүрдүүлэх болон хүч хэрэглэх, түүнчлэн Нэгдсэн Үндэстний зорилгод харшлах ямарваа бусад үйлдлийг цээрлэнэ.”

Дүрмийн 33 дугаар зүйлд маргааныг энхийн замаар шийдвэрлэж болох боломжит арга замыг жагсаасан. Үүнд юуны өмнө хэлэлцээ (negotiation), судалгаа (enquiry), эвлэрүүлэн зуучлал (mediation), эвлэрэл (conciliation), арбитр (arbitration), шүүх (judicial settlement) зэрэг аргыг хэрэглэх, түүнчлэн бүсийн байгууллагуудад хандах, бүсийн гэрээ хэлэлцээрийг баримтлах, эсхүл өөрсдийн сонгосон эвийн бусад аргаар зохицуулахыг онцолсон. Шаардлагатай гэж үзвэл НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл маргаанаа дээрх аргаар шийдвэрлэхийг холбогдох этгээдүүдээс шаардаж болохыг мөн зөвшөөрсөн. Дээрх аргуудыг дор товч судалъя.

Хэлэлцээ (negotiation) гэдэгт талууд маргааны шийдэлд хүрэхээр өөр хоорондоо шууд ярилцах, хэлэлцэхийг хэлнэ. Ихэнх тохиолдолд талууд хууль зүйн аргумент дэвшүүлэн хэлэлцдэг. Гэхдээ хэлэлцээний үед маргааныг дан ганц хууль зүйн үүднээс шийдвэрлэнэ гэсэн үг биш. Практикт талууд эхлээд дипломат хэлэлцээг их төлөв сонгодог. Үүний нэг жишээ нь Монгол бөгөөд тус улсын хувьд өмнө зүгийн хилийн асуудал нь олон зуун жилийн турш хуримтлагдсан түүхэн маргааны шинжтэй байсан бөгөөд “дайнд хүргэхгүйгээр, энхийн замаар шийдвэрлэх” зорилгын хүрээнд Монгол, Хятад улсууд түүхэн баримтад тулгуурлах, газар дээрх бодит байдлыг хамтран шалгах, харилцан зөвшилцөх гэсэн гурван тулгуурт үндэслэн хэд хэдэн үе шат бүхий дипломат хэлэлцээ хийсний дүнд 1962 оны 12 дугаар сарын 26-нд хилийн гэрээнд гарын үсэг зурж, Монгол Улсын өмнө зүгийн хил

олон улсын эрх зүйн хүчинтэйгээр нэг мөр тогтоогдсон байдаг.<sup>30</sup>

Талууд тохиролцоонд хүрэх боломжгүй байвал гуравдагч этгээдийн үйлчилгээг авч болно. Гуравдагч этгээд нь гуравдагч улсаас гадна итгэл хүлээсэн хувь хүн байж болно. Ромын Пап, төрийн тэргүүн, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг нь ийм үүрэг гүйцэтгэж байсан тохиолдол бий.<sup>31</sup>

Маргааныг шийдвэрлэхэд гуравдагч этгээд оролцох нь хэд хэдэн хэлбэртэй. Эдгээрийг ерөнхийд нь заавал биелэгдэх (шүүх, арбитр), заавал эс биелэгдэх (good office, enquiry, mediation, conciliation) гэж ангилж болно.

Талууд хоорондоо шууд харилцахаас татгалзаж буй тохиолдолд гуравдагч тал өөрийн “good office”<sup>32</sup>-г санал болгож болно. Энэ тохиолдолд тухайн этгээд нь өөрөө харилцаа холбооны суваг болох боломжтой. 1980-аад оны үед Персийн буланд Катар, Бахрейн улсуудын хооронд газрын тосоор баялаг арлын нутаг дэвсгэрийн бүрэн эрхийн талаар маргаан эрчимжих үед талууд өөр хоорондоо харилцах аргагүй болсон ба энэ үед талуудын аль аль нь Саудын Араб улсад итгэл хүлээлгэсэнээр тус улс талуудын хооронд харилцах гүүр болж байв. Катар ярилцах зүйлсээ Саудын Араб руу илгээх бөгөөд Саудын Араб түүнийг нь Бахрейн рүү дамжуулна. Хариуг мөн ийм сувгаар ирнэ. Энэ маргаанд, эцэст нь Саудын Араб талуудыг маргаанаа шийдвэрлүүлэхээр Олон улсын шүүхэд хандахыг ятгасан байдаг.<sup>33</sup> Сүүлийн үеийн мэдээгээр Иран-АНУ-ын хямралд Пакистан улс хоёр улсын хооронд good office-той төстэй үүрэг гүйцэтгэж эхлээд байна. Пакистаны өндөр түвшний албан тушаалтнууд хоёр талын байр суурийг дамжуулан хүргэж, буруу ойлголцлыг багасгаж, хурцадмал байдлыг намжаахад тусалж буй<sup>34</sup> бөгөөд ингэхдээ хэлэлцээний

<sup>30</sup> Энэ гэрээ байгуулах урьдач нөхцөл, хэлэлцээний түүх хийгээд гэрээ байгуулсан талаарх дэлгэрэнгүй судалгааг Б.Цэдэн-Иш, *Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс* (Улаанбаатар: 1997); Ц.Энхжаргал, *Монгол Улсын өмнө зүгийн хил* (Улаанбаатар: Адмон принт, 2022)-аас тус тус үзэж болно. Өгүүллийн зохиогч Монгол-Хятадын хилийн маргаан-зөрчилдөөн юу байсан, түүнийг олон улсын эрх зүйн дагуу хэрхэн шийдвэрлэсэн тухай судалгааг тусад нь хийж буй тулд энд цухас дурдав.

<sup>31</sup> Malcolm N. Shaw, *International Law*, 9th ed. (Cambridge: Cambridge University Press, 2021), 1040–1045.

<sup>32</sup> Good offices нь олон улсын маргааныг энхийн аргаар шийдвэрлэх нэг арга бөгөөд үүнд гуравдагч этгээд нь талуудын зөвшөөрлийн үндсэн дээр “найрсаг зуучлагч” байдлаар оролцож, талуудыг хэлэлцээ хийхэд уриалан дэмждэг. Гэхдээ заавал бодит агуулгатай шийдлийн санал дэвшүүлэх шаардлагагүй байдаг.

<sup>33</sup> *Maritime Delimitation and Territorial Questions between Qatar and Bahrain* (Qatar v. Bahrain), Judgment, I.C.J. Reports 2001, paras. 12–18

<sup>34</sup> *How Pakistan managed to get the US and Iran to a ceasefire*, <https://www.aljazeera.com/features/2026/4/8/how-pakistan-managed-to-get-the-us-and-iran-to-a-ceasefire>

агуулгад оролцоогүй, зөвхөн холбох байдлаар ажиллаж байна.

Талуудын хооронд, тухайлбал, эрх зүйн зөрчлийн талаар зөрөлдөөн байгаад зогсохгүй, талууд бүр үйл явдлын талаар санал нийлэхгүй байж болно. Энэ тохиолдолд гуравдагч тал фактыг тогтоох (fact-finding) үүрэг хүлээх замаар маргаанд хүргэж буй жинхэнэ/хүлээн зөвшөөрөхүйц үйл баримт буюу фактыг гаргаж ирэхийг эрмэлздэг. Ийм этгээд нь хувь хүн байж болно. Өнөөгийн практикт их төлөв факт тогтоох комисс байгуулдаг. Жишээ нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (UN Human Rights Council) олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн болзошгүй зөрчлийг мөрдөн шалгахгаар 2011 онд Сирийн Арабын Бүгд Найрамдах Улсын талаар судлах комиссыг байгуулж байжээ.<sup>35</sup> Ийм арга замыг НҮБ-ын 33 дугаар зүйлд “enquiry” гэж тэмдэглэсэн.

Боломжит шийдлийг дэвшүүлэх замаар хэлэлцээнд гуравдагч этгээд идэвхтэй оролцож буй бол энэ нь “эвлэрүүлэн зуучлал” (mediation) байх нь нийтлэг. Иран болон АНУ-ын хооронд 1979 онд үүссэн барьцаалалттай холбоотой хямралд Алжир улсыг ийм үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг.<sup>36</sup>

Гуравдагч этгээд эвлэрүүлэн зуучлалын үеийнхээс илүү эрчимтэй үүрэг гүйцэтгэж байгаа бол энэ нь “conciliation” байх боломжтой. Энд гуравдагч этгээд нь маргаан таслах бүрэлдэхүүнтэй ихээхэн төстэйгөөр нотлох баримтыг сонсох, тайлбаруудыг унших, танилцуулагдсан нотлох баримтын үндсэн дээр зөвлөмж гаргадаг. Шүүхийн гүйцэтгэдэг чиг үүргээс ялгарах байдал нь гуравдагч этгээд нь бодит байдал дээр шүүх биш учраас гаргасан зөвлөмж нь заавал биелэгдэх албагүй. “Conciliation”-ы тодорхой жишээг Ян Майен (Jan Mayen) арал болон түүний эргэн тойрон дахь ус, далайн ёроолоос олдсон баялгийн маргааныг шийдвэрлэхэд Норвеги, Исланд улсууд оролцсоноос<sup>37</sup> харж болно.

Талууд маргаанаа шийдвэрлүүлэхээр бүс нутгийн байгууллагад хандах боломжтой. Бүс нутгийн байгууллага нь маргааныг шийдвэрлэхэд ямар үүрэгтэй оролцох талаар Дүрмийн 33 дугаар зүйлд тодорхой заагаагүй ч бүс нутгийн байгууллагын зүгээс илүү үр нөлөөтэй “good office” болон “эвлэрүүлэн зуучлал”-ын үйлчилгээг талуудад санал болгож болно.

Олон улсын эрх зүйн маргааныг эвийн аргаар шийдвэрлэх арга

---

<sup>35</sup> UN Human Rights Council, “Report of the Independent International Commission of Inquiry on the Syrian Arab Republic,” (2011).

<sup>36</sup> Warren Christopher, *American Hostages in Iran: The Conduct of a Crisis* (New Haven: Yale University Press, 1985), 145–188.

<sup>37</sup> Conciliation Commission on the Continental Shelf Area between Iceland and Jan Mayen, *Report*, (1981).

замуудын дотор шүүх, арбитр ордог. Шүүх, арбитрын алинаар ч маргааныг шийдвэрлэх бай маргаанд холбогдох улсын зөвшөөрөл (State consent) шаардлагатай. Улсын бүрэн эрхт байдлаас үүдэн гардаг логик энд үйлчилдэг бөгөөд энэ ёсоор бүрэн эрхт улс өөрөө зөвшөөрлөө өгөөгүй бол ямар нэгэн эрх мэдлийг хүлээн зөвшөөрөхгүй. Олон улсын эрх зүйд юу арбитрыг шүүхээс ялгадаг вэ гэвэл арбитрын бүрэлдэхүүн нь нэг юм уу түүнтэй холбоотой хэргийг шийдвэрлэхээр байгуулагддаг бол шүүх нь байнгын шинжтэй. Мөн арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх, хэрэглэгдэх хуулийг тогтооход талууд илүү нөлөөтэй байдаг.

## **2. Маргаан шийдвэрлэхэд олон улсын эрх зүйн дагуух аргуудыг хэрэглээ**

XX зуунд улс хоорондын зөрчилдөөн, маргааны нэг гол эх үүсвэр нь нутаг дэвсгэр байсан бол XXI зуунд ч энэ байдал хэвээр байна. Иймээс нутаг дэвсгэрийн маргааныг энхийн аргаар шийдвэрлэх нь олон улсын энх тайван, аюулгүй байдлын төвд байсаар ирсэн гэж хэлж болох юм. Үүнийг энд 1945-2015, 2015 оноос хойш гэсэн хоёр хэсэгт хуваан тайлбарлана.

Криста Э. Виганд (Krista E Wiegand), Эмилия Юстина Пауэлл (Emilia Justyna Powell), Стивен МакДауэлл (Steven McDowell) нар 1945-2015 онд улс хоорондын нутаг дэвсгэрийн маргааныг энхийн аргаар шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийсэн<sup>38</sup> ба үүнд нийт 183 нутаг дэвсгэрийн маргааныг хамруулсан байна.

Тэдний судалснаар маргаантай жилүүдийн дийлэнх буюу гуравны хоёрт маргалдагч талууд ямар нэгэн санал гаргаагүй буюу “идэвхгүй” байдалтай байжээ. Энэ үр дүн нь статус-квог хадгалах өртөг харьцангуй бага, харин маргааныг шийдвэрлэх өртөг өндөр байдаг гэсэн Хут (Huth); Виганд (Wiegand) нарын онолын таамаглалтай нийцэж байна гэж үзсэн байна. Судлаачдын ажигласнаар маргааныг шийдвэрлэхэд хэлэлцээний арга хамгийн түгээмэл хэрэглэгдсэн буюу маргаан бүхий 4 тохиолдол бүрийн нэг нь энэ аргаар шийдвэрлэгдсэн байна. Харин гуравдагч талын оролцоо бүхий аргуудыг бага боловч анхаарал татахуйц байдлаар хэрэглэжээ. Үүнд эрх зүйн хувьд заавал биелэгдэх арга болох шүүх 3.3 хувь, арбитр 1.4 хувь эзэлж байна. Ингэснээр заавал биелэгдэх арга нийтдээ 4.7 хувь байгаа нь өртөг өндөр, эрсдэлтэйд тооцогддогтой холбоотой гэж дүгнэжээ.<sup>39</sup>

Маргалдаж буй талуудын 85 хувь нь эхний алхмаа хоёр талын

<sup>38</sup> Krista E. Wiegand, Emilia Justyna Powell, and Steven McDowell, “The Peaceful Resolution of Territorial Disputes Dataset, 1945–2015,” *Journal of Peace Research* 58, no. 2 (2021): 304–14, <https://www.jstor.org/stable/48631663>.

<sup>39</sup> Мөн тэнд, 309

хэлэлцээгээр эхлүүлдэг.<sup>40</sup> Гэхдээ гуравдагч талын оролцоо бүхий арга руу шилжих үйл явц нь шугаман бус шинжтэй. Энэ нь гуравдагч талаас санал гаргалаа гээд хэлэлцээ шууд буурдаггүй, мөн заавал биелэгдэх болон заавал эс биелэгдэх аргын хэрэглээ шууд өсдөггүй гэсэн үг юм. Зарим үед заавал биелэгдэх арга нэмэгдсэн ч дараагийн жил хэлэлцээ рүү дахин буцах тохиолдол байна. Энэ нь стратегийн хувьд улсуудын хандлага цаг хугацааны явцад өөрчлөгдөж, маргаан шийдвэрлэхэд институтийн түвшний сонголт хийх нь тогтвортой биш болохыг харуулна.

Цаг хугацааны нөлөөг илүү нарийвчилбал, заавал биелэгдэх аргыг санал болгох магадлал маргаан эхэлснээс хойш 35–40 жилийн хооронд оргилдоо хүрч, эргээд буурдаг. 1945–1980 онд арбитр эсхүл шүүхээр маргаан шийдвэрлэхийг санал болгох нь огцом буурсан бол 1980 оноос хойш шүүхийн шийдвэрийн хэрэглээ эргэн өсөж, 2015 онд 1945 оны түвшнээс давсан байна. Арбитрын хэрэглээний өсөлт удаан боловч 2010-аад онд Олон улсын арбитрын байнгын шүүх (РСА)-д маргаан шийдвэрлэх явдал нэмэгдсэнтэй уялдан өссөн байна. Үндсэндээ 1945-2015 онд улс хоорондын маргааныг эвийн аргаар шийдвэрлэсэн байдлаас дараах нийтлэг дүр зураг ажиглагдана. Үүнд нэгдүгээрт, заавал эс биелэгдэх аргын хэрэглээ цаг хугацааны явцад өссөн; хоёрдугаарт, цаг хугацааны нөлөө шугаман бус бөгөөд оргилтой, уналттай; гуравдугаарт, маргаан удаан үргэлжлэх тусам заавал биелэгдэх аргыг хэрэглэх магадлал буурах хандлагатай; дөрөвдүгээрт, Хүйтэн дайны үеийн түүхэн нөхцөл байдал нь заавал биелэгдэх аргын санал болгох эсэхэд хүчтэй нөлөөлж байжээ.

Цаашлаад дээрх судалгаанд ерөөс заавал биелэгдэх аргыг маргаанд санал болгох, сонгоход дараах хэд хэдэн нийтлэг хүчин зүйл нөлөөлж байна гэж үзсэн байна. Үүнд:

а) Ардчиллын түвшин цаг хугацааны явцад өсөх нь тухайн улсыг арбитр болон шүүхийн шийдвэр зэрэг заавал биелэгдэх аргыг сонгох магадлалыг нэмэгдүүлдэг. Гэвч ардчилсан улсууд авторитар улсуудтай харьцуулахад анхнаасаа илүү өндөр магадлалтайгаар ийм арга сонгодог гэх баттай нотолгоо байхгүй.

б) Материаллаг чадавхийн нөлөө хоёр талтай. Хүчтэй улс заавал биелэгдэх аргыг санал болгох нь бага боловч тухайн улсын хүчний түвшин цаг хугацааны явцад нэмэгдэх үед арбитр, шүүхээр шийдвэрлэхийг сонгох нь өсөх хандлагатай. Энэ нь хүчний динамик өөрчлөгдөхөд улсуудын стратегийн тооцоолол өөрчлөгдөж болдгийг харуулна.

с) Энхийн гэрээний тал болох нь заавал биелэгдэх аргыг санал

---

<sup>40</sup> Мөн тэнд

болгох магадлалыг нэмэгдүүлдэг боловч шинэ гэрээнд нэгдэх зэрэг цаг хугацааны явцад нэмэгдсэн үүрэг амлалт нь ийм саналын магадлалыг бууруулдаг. Энэ нь олон улсын институтийн оролцоо улсуудын хандлагад эерэг, саармаг аль ч нөлөөг үзүүлж болдог адармаатай механизмыг илтгэнэ.

d) Цаг хугацаатай холбоотой хувьсагчид шугаман бус, хүчтэй нөлөөтэй. Маргааны үргэлжлэх хугацаа болон түүхэн нөхцөл байдал нь заавал биелэгдэх аргыг санал болгох магадлалд мэдэгдэхүйц нөлөөлдөг бөгөөд энэ нь маргааны амьдралын мөчлөгийн туршид улс орнуудын стратеги тогтвортой биш, харин хувьсан өөрчлөгдөж байдгийг харуулдаг.

Тэгвэл 2015 оноос хойш хэрхсэн бэ гэдэг асуулт зохих ёсоор гарна. Нөхцөл байдлыг дор тайлбарлах гэж оролдоё.

Юуны өмнө, хоёр талын хэлэлцээ нь нутаг дэвсгэрийн маргааныг шийдвэрлэх хамгийн түгээмэл арга хэвээр байна. Нөгөө талаас бүс нутгийн зуучлалын ач холбогдол нэмэгдэж байна. Африк, Зүүн Өмнөд Ази, Латин Америкийн улсуудын ихэнх маргаанд хэлэлцээний суурийг бүрдүүлэхэд Африкийн холбоо, Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо, Өмнөд Африкийн Хөгжлийн нийгэмлэг, Америкийн Улсуудын холбоо гэх мэт бүс нутгийн байгууллагуудын оролцоо өссөн. Бүс нутгийн зуучлал нь улс төрийн хувьд уян хатан, эдийн засгийн хувьд зардал багатай учраас олон улсын шүүхийн өмнөх үр дүнтэй арга<sup>41</sup> болохын сацуу урт хугацааны маргаанд талуудын байр суурийг зөөлрүүлж, хүч хэрэглэх эрсдэлийг бууруулдаг гэж судлаачид үздэг.<sup>42</sup>

Өмнөхтэй харьцуулахад 2015–2026 онд олон улсын шүүх, арбитрын хэрэглээ өсөж байна. Олон улсын арбитрын байнгын шүүх (РСА) болон Олон улсын шүүх (ICJ)-ийн шийдвэрүүд нь тооны хувьд цөөн боловч эрх зүйн тодорхой байдал бий болгох, бусад маргаанд прецедент маягийн нөлөө үзүүлэх<sup>43</sup>, хэлэлцээний хүрээг өөрчлөх “шүүхийн гадуурх нөлөө” (out-of-court effects)-г үүсгэх зэргээр бодит байдал дээр өргөн хүрээний үр дагавартай байж болно. Өмнөд Хятадын тэнгисийн маргааныг Олон улсын арбитрын байнгын шүүхээс шийдвэрлэсэн (South China Sea Arbitration (Philippines v. China), 2016) нь энэ хандлагын нэг тод жишээ бөгөөд Роберт Бэкман (Robert Beckman) энэ шийдвэрийг “олон улсын эрх зүй улс төрийн өндөр эрсдэлтэй маргаанд ч бодит нөлөө үзүүлж чаддаг” гэж

<sup>41</sup> Laurie Nathan, “The Challenges of Mediation in Africa,” *African Affairs* 115, no. 458 (2016): 475.

<sup>42</sup> Tania Dress, “Mediation in Protracted Territorial Conflicts,” *Journal of Peacebuilding & Development* 14, no. 2 (2019): 147.

<sup>43</sup> Олон улсын эрх зүйд шүүхийн шийдвэр нь албан ёсоор прецедентийн шинжгүй ч практикт зарим шийдвэр эш татагдах нь олон.

дүгнэсэн.<sup>44</sup> Үүнтэй адил Олон улсын шүүхийн шийдвэрлэсэн *Кени ба Сомалийн маргаан* (Kenya v. Somalia (2021)), *Болив ба Чилийн маргаан* (Bolivia v. Chile (2018)) болон хараахан шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа *Гуана ба Венесуэлийн маргаан* (Guyana v. Venezuela) нь практикт үр дүнгээ өгсөн.

Пауэлл (Powell)-ийн судалгаагаар улсууд зөвхөн албадлагын зорилгоор буюу албан ёсны шийдвэр гаргуулах, шийдвэрийн биелэлтийг хангуулах үүднээс бус явагдаж буй хэлэлцээнд давуу тал олж авах, эсрэг талын хүлээлтийг өөрчлөх, дотоод улс төрийн аудиторудад дохио өгөх зэрэг стратегийн зорилгоор арбитр, шүүхэд хандах тохиолдол цөөнгүй байдаг нь илэрчээ.<sup>45</sup> Өөрөөр хэлбэл, энэ нь олон улсын шүүх оршин буй нь өөрөө хэлэлцээний динамикт нөлөөлдөг “institutional shadow” үүсгэдэг гэж дүгнэсэн байдагтай холбогдоно.<sup>46</sup>

Гэхдээ 2015 оноос хойш олон маргаан эрх зүйн хувьд эцэслэн шийдэгдээгүй. Харин улс төрийн хувьд олон маргаанд улсууд байгаа байдал буюу “статус-кво”-г хадгалах явцтай байна. Үүнийг Тэйлор Фравел (Taylor Fravel) хүчний тэнцвэр, дотоод улс төрийн тогтвортой байдал, гадаад бодлогын зорилгоос хамаарсан стратегийн сонголт гэж нэрлэсэн.<sup>47</sup>

Пол Хут (Paul Huth), Дэн Линдли (Lindley) нар удаан үргэлжилсэн маргаанд заавал биелэгдэх механизмыг хэрэглэх магадлал буурдаг<sup>48</sup> гэж тайлбарласан. Нутаг дэвсгэрийн зарим маргаан (жишээлбэл, Орос–Украйн, Нагорно-Карабах) өнөө хэр олон улсын шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нь энэ дүгнэлт үндэслэлтэй болохыг илтгэнэ. Энд жишээлбэл, Орос-Украины маргаанд 2022 оноос цэргийн хүч хэрэглэх явдал дагалдсан нь НҮБ-ын дүрмийн 2 дугаар зүйлийн (4) дэх хэсэгт заасан хүч хэрэглэхийг хориглосон зарчим ба бодит практик хоорондын зөрчлийг улам тодруулаад байна.

## VI. Дүгнэлт

Нутаг дэвсгэрийн маргаан нь олон улсын эрх зүй, олон улсын улс төрийн нөхцөл байдал, хүчний динамик, дотоод улс төрийн харилцан

<sup>44</sup> Robert Beckman, “The South China Sea Arbitration: Implications for International Law,” *Ocean Development & International Law* 48, no. 3 (2017): 197.

<sup>45</sup> Emilia Justyna Powell, *The Shadow of International Courts* (Cambridge: Cambridge University Press, 2020), 35–41.

<sup>46</sup> Krista E. Wiegand and Emilia J. Powell, “International Courts and Bargaining Dynamics,” *Journal of Peace Research* 60, no. 4 (2023): 710–14.

<sup>47</sup> M. Taylor Fravel, “Power Shifts and Territorial Conflict,” *International Security* 45, no. 3 (2020): 56–92.

<sup>48</sup> Paul Huth and Dan Lindley, “The Duration of Territorial Disputes,” *Conflict Management and Peace Science* 36, no. 4 (2019): 379–99.

үйлчлэлд оршдогийн хувьд түүнийг шийдвэрлэх нь дан ганц эрх зүйн асуудал биш, үүн дээр нэмээд стратегийн, институтийн, түүхэн шинжтэй олон талт процесс орж ирэх юм.

Энэ өгүүллийн эхний хэсэгт маргаан оршин буй эсэхийг тогтоох Олон улсын шүүх (ICJ)-ийн шалгуур, “позитив эсэргүүцэл (positive opposition)”-ын тухай ойлголт, нутаг дэвсгэрийн маргааны ангиллын эрх зүйн үр дагаврыг тайлбарласан нь маргааныг зөв тодорхойлох, улмаар шийдвэрлэх аргыг сонгоход нөлөөлдөг болохыг харуулсан.

Удаагаар нь, НҮБ-ын Дүрмийн дагуу маргааныг энхийн аргаар шийдвэрлэх механизмын эрх зүйн үндэс, good offices, enquiry, mediation, conciliation, арбитр, шүүх зэрэг аргуудын онцлогийг авч үзсэн.

Улмаар 1945–2015 онд нутаг дэвсгэрийн маргааныг энхийн аргаар шийдвэрлэсэн үр дүнг судлахад хэлэлцээг хамгийн түгээмэл арга болгон ашиглаж ирсэн байна. Үүнд Монгол-Хятадын хилийн маргааны шийдвэрлэлтийг нэг жишээ болгон товч байдлаар нэмж оруулсан. Нөгөө талдаа улсуудын дийлэнх нь маргаанаа идэвхгүй байдалд хадгалах шинжтэй бөгөөд маргаан удаан үргэлжлэх тусам заавал биелэгдэх шийдвэр гаргадаг механизм болох шүүх, арбитрыг сонгох магадлал буурчээ.

Цаашлаад 2015 оноос хойш бүс нутгийн зуучлалын ач холбогдол өсөж, Олон улсын арбитрын байнгын шүүх (РСА) болон Олон улсын шүүх (ICJ)-ийн шийдвэрүүд маргааны динамикт бодит нөлөө үзүүлж эхэлсэн. Гэхдээ олон маргаан эрх зүйн хувьд эцэслэн шийдэгдээгүй, улс төрийн хувьд статус-квогоо хадгалсан хэвээр байгааг энд дурдах нь зүйтэй.

Эцэст нь, нутаг дэвсгэрийн маргааныг энхийн аргаар шийдвэрлэх нь олон улсын эрх зүйн зайлшгүй шаардлага төдийгүй бодит практикт улс орнуудын стратегийн тооцоолол, институтийн нөлөө, бүс нутгийн динамиктай салшгүй холбоотой. Ирээдүйд заавал биелэгдэх болон заавал эс биелэгдэх механизмыг хослуулан хэрэглэх, бүс нутгийн зуучлал, олон улсын шүүхийн гүйцэтгэх үүрэг улам бүр чухалчлагдах төлөвтэй байна. Иймээс нутаг дэвсгэрийн маргааныг энхийн аргаар шийдвэрлэх нь олон улсын энх тайван, аюулгүй байдлын үндсэн тулгуур байдлаа хадгалсаар байх нь дамжиггүй.

[Ном зүй]

- НҮБ-ын Дүрэм, 1945 он.
- Далайн эрх зүйн тухай НҮБ-ын конвенц, 1982 он.
- Цэдэн-Иш, Б. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. Улаанбаатар, 1997 он.
- Энхжаргал, Ц. Монгол Улсын өмнө зүгийн хил. Улаанбаатар: Адмон принт, 2022 он.
- Beckman, Robert. "The South China Sea Arbitration: Implications for International Law." *Ocean Development & International Law* 48, no. 3 (2017): 197–217.
- Blumenwitz, Dieter. "The Sudeten German Question." *Review of Central and East European Law* 20, no. 1 (1994).
- BoutrosGhali, Boutros. *Statement to the UN Security Council*. U.N. Doc. A/47/277 (June 17, 1992).
- Christopher, Warren. *American Hostages in Iran: The Conduct of a Crisis*. New Haven: Yale University Press, 1985.
- Conciliation Commission on the Continental Shelf Area between Iceland and Jan Mayen. Report, 1981.
- De La Pradelle, Paul. *La Frontière: Étude de Droit International*. Paris, 1928.
- Dreher, Tania M. "Mediation in Protracted Territorial Conflicts." *Journal of Peacebuilding & Development* 14, no. 2 (2019): 147–162.
- Fravel, M. Taylor. "Power Shifts and Territorial Conflict." *International Security* 45, no. 3 (2020): 56–92.
- Huth, Paul, and Dan Lindley. "The Duration of Territorial Disputes." *Conflict Management and Peace Science* 36, no. 4 (2019): 379–399.
- Jennings, Robert Y. "Reflections on the Term 'Dispute'," in *Essays in Honour of Wang Tieya*, ed. Ronald MacDonald. Dordrecht: Martinus Nijhoff, 1993.
- Kohen, Marcelo G., and Mamadou Hébié. "Territorial Conflicts and Their International Legal Framework." In *Research Handbook on Territorial Disputes in International Law*, edited by Marcelo G. Kohen and Mamadou Hébié, 1–20. Cheltenham: Edward Elgar, 2018.
- Nathan, Laurie. "The Challenges of Mediation in Africa." *African Affairs* 115, no. 458 (2016): 475–493.
- Powell, Emilia Justyna. *The Shadow of International Courts*. Cambridge: Cambridge University Press, 2020.
- Shaw, Malcolm N. *International Law*. 9th ed. Cambridge: Cambridge University Press, 2021.
- UN Human Rights Council. "Report of the Independent International Commission of Inquiry on the Syrian Arab Republic." 2011.
- Wiegand, Krista E., Emilia Justyna Powell, and Steven McDowell. "The Peaceful Resolution of Territorial Disputes Dataset, 1945–2015." *Journal of*

*Peace Research* 58, no. 2 (2021): 304–314.

Wiegand, Krista E., and Emilia Justyna Powell. “International Courts and Bargaining Dynamics.” *Journal of Peace Research* 60, no. 4 (2023): 707–720.

*Mavrommatis Palestine Concessions (Greece v. United Kingdom)*. PCIJ Series A, No. 2 (1924).

*Aegean Sea Continental Shelf (Greece v. Turkey)*, 1978 I.C.J.Reports.

*Land and Maritime Boundary between Cameroon and Nigeria (Cameroon v. Nigeria: Equatorial Guinea intervening)*. Preliminary Objections, 1998 I.C.J. 275; Merits, 2002 I.C.J. 303.

*Land, Island and Maritime Frontier Dispute (El Salvador/Honduras: Nicaragua intervening)*. Judgment, 1992 I.C.J. 351.

*Maritime Delimitation and Territorial Questions between Qatar and Bahrain (Qatar v. Bahrain)*, 2001 I.C.J. Reports

*Obligations concerning Negotiations relating to Cessation of the Nuclear Arms Race and to Nuclear Disarmament (Marshall Islands v. United Kingdom)*. Preliminary Objections, 2016 I.C.J. 1.

*South West Africa (Ethiopia v. South Africa; Liberia v. South Africa)*. Preliminary Objections, 1962 I.C.J. 319.

*Territorial and Maritime Dispute (Nicaragua v. Colombia)*. Preliminary Objections, 2007 I.C.J. 832; Judgment, 2012 I.C.J. 624.

*Frontier Dispute (Burkina Faso/Niger)*, Judgment, 2013 I.C.J. 44.

*Frontier Dispute (Burkina Faso/Mali)*, Merits, 1986 I.C.J. 554, 563.

*Croatia/Slovenia Arbitration*. Final Award (PCA), 2017.

*South China Sea Arbitration (Philippines v. China)*. Final Award (PCA), 2016.

United Nations, United Nations Convention on the Law of the Sea, [https://www.un.org/depts/los/convention\\_agreements/texts/unclos/unclos\\_e.pdf](https://www.un.org/depts/los/convention_agreements/texts/unclos/unclos_e.pdf)

Wiegand, Krista E. et al., dataset, <https://www.jstor.org/stable/48631663>.

Монгол хэлний их тайлбар толь, <https://www.mongoltoli.mn/dictionary/detail/23799>

Al Jazeera, “How Pakistan managed to get the US and Iran to a ceasefire”, <https://www.aljazeera.com/features/2026/4/8/how-pakistan-managed-to-get-the-us-and-iran-to-a-ceasefire>

**[Abstract]**

**Territorial Disputes and Their Settlement  
Under International Law**

**Tuulaikhuu Enkhee**

*Master of Laws (LL.M.)*

*Lecturer at the Public Law Department,  
School of Law, National University of Mongolia*

*Ulaanbaatar, Mongolia*

Territorial disputes are complex phenomena situated at the intersection of international law, historical legacies, power dynamics, and domestic political factors. Their peaceful settlement depends on multidimensional conditions that extend beyond legal regulation alone. This article examines territorial disputes through the interplay between legal doctrine and political practice, explaining the International Court of Justice’s criteria for determining the existence of a dispute and the significance of “positive opposition.” It further analyzes the legal foundations of peaceful settlement mechanisms under the UN Charter and explores how states’ strategic interests and institutional environments shape their choice among these methods. An assessment of state practice from 1945 to 2015 shows that negotiation has been the predominant method, while the likelihood of selecting binding mechanisms declines as disputes become more protracted. Developments since 2015 indicate a growing role for regional mediation and an increasing influence of decisions by international courts and arbitral tribunals on dispute dynamics, even as many disputes persist under conditions of political status quo. The findings demonstrate that although the peaceful settlement of territorial disputes remains a core requirement of international law, its practical effectiveness is deeply conditioned by strategic calculations, institutional constraints, and regional dynamics.

**[Keywords]**

Territorial Disputes, Positive Opposition, UN Charter, Peaceful Settlement of Disputes, International Adjudication and Arbitration.